



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар

A/65

Улаанбаатар хот

Нийтийн биеийн тамир, спортын олон талт
арга хэмжээг дэмжих тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийг спортын 17 төрлөөр хичээллүүлэхийг нэгдүгээр, Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, сурталчлах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, Монголын Бүх Ард түмний спортын XVI их наадам, Хүүхдийн спортын VIII их наадмын тэмцээнд оролцох, Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг, тамирчдын 2025 онд гадаад дотоодын уралдаан тэмцээн, олон улсын хамтарсан бэлтгэлд шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх ажлын хүрээнд дүүргийн Биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, өсвөрийн шигшээ багийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэст, өсвөрийн шигшээ баг, тамирчдын бэлтгэл сургуулилтыг тасралтгүй явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг дүүргийн Биеийн тамир, спортын хороо (Р.Очирпүрэв)-д тус тус үүрэг болгосугай.

3.Үйл ажиллагаанд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Лхагвасүрэн)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны A/17 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010217

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 27 өдрийн 165 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГИЙН ТӨРӨЛ

1. Чөлөөт бөх
2. Сагсан бөмбөг
3. Волейбол
4. Жүдо бөх
5. Шатар
6. Ширээний теннис
7. Тэшүүр
8. Хоккей
9. Бокс
10. Спортын гимнастик
11. Усан спорт
12. Хөл бөмбөг
13. Хөнгөн атлетик
14. Үндэсний бөх
15. Таеквондо
16. Хүндийг өргөлт
17. Холимог тулаан